


Бидний нутаг OUR LAND


Монгол улсын Хэнтий болон Дорнод аймгууд дахь
Хүний эрхийн хамгаалагч, Байгаль орчин болон
хүй олонд үзүүлж буй уул уурхайн нөлөөллийг
баримтжуулах томилолтын тайлан

Fact-Finding Mission Report on the Impacts
of Mining on Defenders, Environment and
Local Communities in Khentii and Dornod Provinces,
Mongolia





**"Орон нутагт маань уул
уурхай хэрэггүй."
(Биндэр сумын иргэн)**



**"We don't need and
don't want mining in
our land."
(Binder Soum resident)**

Хураангуй

2000 оны дунд үеэс эхлэн уул уурхайн салбар нь Монгол улсын экспортын тэргүүлэгч болсон төдийгүй өнгөрсөн арван жилд огцом хөгжсөн эдийн засгийг бий болгосон хэдий ч эдийн засгийн өсөлт сүүлийн хэдэн жил удааширч өсөн нэмэгдсэн уул уурхайн үйл ажиллагаа нь Монгол улсын эдийн засгийн бодлого, нийгмийн хөгжил болон байгаль орчинд нилээдгүй нөлөөлсөн юм.

Уул уурхайн салбарын тэлэлтээс үүдэн бий болсон эрс өөрчлөлтүүдийг харгалзан Хүний эрх болон хөгжлийн Азийн Форум (Форум Ази) өөрийн Монгол улс дахь гишүүн байгууллага болох Хүний Эрх Хөгжил Төвтэй (ХЭХТ) хамтран уул уурхайн хүний эрх болон байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөг авч үзсэн билээ. 2012 онд Форум Ази болон ХЭХТ Монгол улсын өмнөд бүсэд баримтжуулах томилолтоор ажиллаж хүний эрхийн хамгаалагчдын нөхцөл байдал, уул уурхайгаас үүдсэн зөрчлүүдийг ил болгосон. Улмаар 2018 онд ХЭХТ уул уурхайгаас үүдэлтэй сөрөг нөлөөлөл, иргэний нийгмийн зүгээс шударга ёс, эгэх хариуцлагын тал дээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг Форум-Азийн бизнес ба хүний эрхийн тухай ажлын тайланд оруулсан.

Executive Summary

Since mid-2000s, the mining sector has been driving Mongolia's exports, leading the country to be one of the fastest growing economies until 2015. However, while in recent years the economic growth is slowing down, the increased number of mining operations profoundly affects Mongolia's economic policies, social dynamics and environment.

In light of drastic changes brought by the expansion of the mining sector in Mongolia, the Asian Forum for Human Rights and Development (FORUM-ASIA) and its Mongolian member organisation Centre for Human Rights and Development (CHRD) have been looking into mining's impact on human rights and environment. In 2012, the two organisations conducted a first fact-finding mission (FFM) in the southern part of Mongolia, looking into the situation of human rights defenders (HRDs) exposing violations related to mining. In 2018, CHRD portrayed the negative impacts of mining, as well as efforts deployed by civil society to demand justice and accountability in FORUM-ASIA's working paper on business and human rights.

2019 оны 5-р сарын 5-10-ны өдрүүдэд ХЭХТ болон Форум-Ази Монгол улсын зүүн хойд бүсийн нутаг болох Хэнтий болон Дорнод аймгуудад хоёр дахь баримтжуулах томилолтоор ажилласан болно. Баримтжуулах томилолтоор ажилласан багийнхан орон нутгийн ард иргэд, албан тушаалтнууд болон уул уурхайн компаниудтай уулзах явцдаа хүний эрхийн хамгаалагчид, байгаль орчин болон орон нутгийн ард иргэдийн амьжиргаанд уул уурхайн үйл ажиллагааны үзүүлж буй сөрөг нөлөөлөл болон үр дагаврыг баримтжуулсан юм.

From 5 to 10 May 2019, CHRD and FORUM-ASIA conducted a second FFM in the north eastern aimags (provinces) of Khentii and Dornod. By meeting with local communities, authorities, and mining companies, the FFM team documented the repercussions of mining operations on the work of HRDs, environment, and livelihoods of local communities.

Хэнтийн аймгийн Биндэр сумынхны хувьд унд, хоол тэжээлийн гол эх үүсвэр болсон биологийн олон төрөлт байдлаар баялаг Онон голын ай сав газарт уурхайн үйл ажиллагааг зөвшөөрсөн нь ихээхэн эрсдэл учруулж байгааг нутгийн иргэд, албан тушаалтнууд болон малчид хэлж байсан юм. Орон нутгийн иргэд Онон голын салаа болон ойн зурвас газарт маш ойрхон гурван уурхай ажилладаг тухай ярьсан төдийгүй авилга хээл хахуулийн асуудал үүссэн, байгаль орчны доройтол, бохирдлын шинж тэмдэг илрээд байгааг баримтжуулах томилолтоор ажилласан багийнхан тэмдэглэжээ. Батширээт сумын захиргаа уул уурхайг дэмжиж байгаа нь мөн голын дагуу амьдардаг иргэдийн хооронд маргаан үүсэх эрсдэлийг нэмэгдүүлж байна.


Local communities, authorities, and herders living in Binder Soum (District), Khentii Aimag, denounced the potential risks of allowing mining operations in the Onon River basin area, a key source of water and food for the community with rich biodiversity. The FFM team recorded their concerns of both alleged corruption and early signs of environmental degradation and pollution, acknowledging how three mining sites are indeed located in the proximity of Onon River's tributaries and forest areas. Being the local authorities of the upstream Soum of Batshireet in favour of the mining operations, there are increasing risks of clashes between the downstream and upstream communities.



Precious stones confiscated from ninja miners in Batnorov Soum, Khentii Aimag [photo taken by Batnorov local authorities]

Орон нутгийн иргэд, малчдын амьжиргаа болон аюулгүй байдалд дан ганц бүртгэлтэй уул уурхайн компаниуд аюул занал учруулж буй биш юм. Нинжа гэж нэрлэгддэг гар аргаар олборлогчид Батноров сумын бэлчээрийн нутагт эрдэнийн чулуу болон үнэт металл хайх зорилгоор нүх ухаж бэлчээрийн нутгийн экосистемийг алдагдуулж байна. Орон нутгийн засаг захиргаа, Монгол улсын ХЭҮК-ийн салбарын ажилтан руу гар аргаар олборлогчид дайрсан, айлган сүрдүүлсэн хэд хэдэн тохиолдол байгаа төдийгүй нинжа нар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны ямар нэг дүрэм стандартгүйгээр өдөржин шөнөжин ажилладаг ч туйлын ядуу амьдардаг хэвээр байгааг тайлагнасан байна.

The livelihoods and safety of local communities and herders are not only threatened by registered mining companies. Artisanal miners, also known as ninja miners, compromised the ecosystem of the pasture lands of the Batnorov Soum by digging holes and tunnels in search of gemstones or precious metals. The report documents threats and attacks against local authorities and a representative of the National Human Rights Commission of Mongolia by ninja miners, recognising at the same time how the latter live in a condition of extreme poverty, working day and night without any safety standards in place.



Хэдэн үеэрээ нутаг орондоо амьдарч буй орон нутгийн иргэд, малчид газрын гэрчилгээтэй хэдий ч газар нутгаа алдаж байна. Монгол улсын Газрын тухай хуулийн цоорхойгоос үүдэн газрын гэрчилгээ олгогдсоноос хойш хоёр жилийн хугацаанд газраа зориулалтын дагуу ашиглаагүй (гол төлөв хашаалаагүй бол) нөхцөлд газраа алдах магадлалтай. Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын нутагт амьдарч байсан 13 өрх 2018 онд үйл ажиллагаагаа эхэлсэн алтны томоохон уурхайн компани болох Степ Гоулд компанитай нөхөн төлбөрийн хэлцэл хийхээс өөр аргагүйд хүрчээ. Степ Гоулд компани байгаль орчин болон малчдын амьжиргаанд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг буруулах арга хэмжээ авсан гэсэн хэдий ч орон нутгийн захиргааны төлөөлөгч зэрэг орон нутгийн цөөн иргэд уурхайн эсрэг тэмцэл өрнүүлж олборлолтын лицензийг олгох явц хуулийн дагуу байгаагүй гэж мэдэгдэж байгааг тайланд оруулсан. Steppe Gold компанийн хамгаалалтын ажилтнууд Хүний эрхийн хамгаалагчдад халдсаныг баримтжуулсан болно.

Bank of the Onon River in Binder Soum, Khentii Aimag

Local community members and herders can end up losing their lands despite having lived there for generations and owning a land certificate. Due to shortcomings in the Mongolian Land Law, it is possible to lose the land if not used for a specific purpose within two years' time from the moment a land certificate is issued. 13 families who used to live in the surroundings of the Tsagaan-Ovoo Soum in Dornod Aimag now have to negotiate compensations with Steppe Gold, a large gold mining company that started operations in 2018. The report finds that despite alleged efforts of Steppe Gold to minimise negative impacts on environment and community livelihoods, few community members, including representatives of the local Government, have been actively protesting against the mining operations, denouncing irregularities in the mining licence's approval process. Moreover, the report documents attacks against HRDs by the security personnel allegedly hired by Steppe Gold.



A tributary of the Onon River in Batshireet Soum, close to Aivuuntes mining site

Баримтжуулах томилолтын явцад хууль ёсны болон хууль бус уул уурхайн үйл ажиллагаа нь орон нутгийн ард иргэд, албан тушаалтан, Хүний эрхийн хамгаалагчдын олонхийн санаа зовоосон асуудал болсныг ХЭХТ болон Форум-Ази олж тогтоосон. Орон нутгийн ард иргэд уул уурхайн үйл ажиллагаа нь тэдний аюулгүй байдал хийгээд байгаль орчинд үзүүлэх эрсдэлийн талаар ойлголт сайтай байна. Хүний эрхийн хамгаалагчид, орон нутгийн ард иргэд, мөн орон нутгийн албан тушаалтнууд айлган сүрдүүлэг, доромжлолыг үл тоон Үндсэн хуулиар олгогдсон аюулгүй, эрүүл орчинд амьдрах эрхээ шаардаж, уул уурхайтай тэмцэж байна. (Монгол улсын Үндсэн хууль, 16.2-р зүйл).

Over the course of the FFM, CHRD and FORUM-ASIA found how mining operations, whether legal or illegal, are a major cause of concern and polarisation for most local communities, authorities and HRDs, who are all very well aware of the risks that these pose to their security and environment. For this, despite threats and intimidations, HRDs, local communities or even local authorities, continue to mobilise themselves, demanding respect for their constitutional right to live in a safe and healthy environment (Constitution of Mongolia, Article 16.2).

Ард иргэдээс цуглуулсан мэдүүлэг, нотолгоо баримт дээр тулгуурлан энэхүү Тайланд Монгол улсын Засгийн Газар, Хэнтий аймаг, Биндэр, Батширээт болон Цагаан-Овоо сумд, Айвуунтэс, Пегматит болон Стэп Гоулд уул уурхайн компаниуд, НҮБ-ын Хүний эрхийн хамгаалагчдын нөхцөл байдлын Тусгай Илтгэгч нарт тусгайлан зөвлөмжүүдийг оруулсан болно.

Based on the collected testimonies and in light of Mongolian laws and obligations under international human rights law, the report provides a set of tailored recommendations to: Mongolian Government; Khentii Aimag; soums of Binder, Batshireet and Tsagaan-Ovoo; mining companies Aivuuntes, Pegmatite, and Steppe Gold; and United Nations Special Rapporteur on the situation of HRDs.



An artificial pond in Aivuuntes mining site in Batshireet Soum

Дүгнэлт

Уул уурхайн үйл ажиллагаа нь цар хүрээ, онцлогоос үл хамааран Баримтжуулах томилолтын багийнхны очсон сумдын ард иргэд, байгаль орчинд тодорхой аюул эрсдэл учруулж байна.

Онон голын ай сав нутагт усны эх үүсвэр, ой бүхий газар нутагт ойр орших уурхайнууд нь экосистемд аюул учруулж байгаа төдийгүй орон нутгийн иргэд болон малчдын амьжиргааны эрхэд халдаж буй юм. Орон нутгийн түвшинд Юү энд Би, Айвуун тэс, Пегматит компаниудын үйл ажиллагаа нь Монгол хүн аюулгүй, эрүүл орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг баталгаажуулсан Монгол улсын Үндсэн хуулийн 16.2-р зүйлийг зөрчиж байгаа юм. Цаашилбал, тэдний үйл ажиллагаа нь гол мөрөн, ойн сан бүхий газрын ойр орчимд уурхайн үйл ажиллагааг хязгаарлах зорилготой 2015 онд уул уурхайг дэмжсэн нэмэлт өөрчлөлт оруулсан хэдий ч Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн үндсэн үзэл санаатай зөрчилдөж байгаа юм. Монгол улс Эдийн засаг, Нийгэм болон Соёлын эрхийн тухай олон улсын пактад нэгдсэн улсын хувьд 11-р зүйлд заасны дагуу ард иргэдийнхээ аж төрөх, амьдралынхаа нөхцлийг сайжруулах эрхийг хамгаалах үүрэг хүлээсэн болно.

Conclusion

Mining operations, regardless of their scale and nature, are posing a series of concrete threats to the people and environment of the soums visited by the FFM team.

In the Onon River basin area, the proximity of the mining sites to water sources and forest areas threatens the ecosystem and the right to livelihoods of local communities and herders. At the domestic level, the operations of U&B (currently closed), Aivuuntes, and Pegmatite could violate Article 16.2 of the Mongolian Constitution, guaranteeing the right of Mongolian citizens to live in a safe and healthy environment, protected against environmental pollution and ecological imbalance. Furthermore, their operations go against the very essential spirit of the Law To Prohibit Mineral Exploration And Mining Operations At River Headwaters, Protected Zones Of Water Reservoirs And Forested Areas, which despite the mining-friendly amendment of 2015, rightly captured the need to ensure that no mining is allowed in proximity to rivers and forest reserve areas. As state party to the International Covenant on Economic, Social, and Cultural Rights (ICESCR), Mongolia has also the duty to protect the right to livelihoods of its people under Article 11.

Энэхүү үүргээ хэрэгжүүлэхгүй байгаа нь НҮБ-ын Хүний эрх болон Байгаль орчны асуудал хариуцсан Тусгай илтгэгчийн бий болгосон Хүний эрх болон Байгаль орчны суурь зарчмуудтай зөрчилдөж байна.¹ Монгол улс нь мөн Биологийн олон янз байдлын Конвенци болон Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газрын тухай Рамсарын Конвенцид нэгдсэний хувьд өөрийн нөөцөө тогтвортой байдлаар ашиглан биологийн олон янз байдлыг хамгаалах үүрэг хүлээсэн.² Рамсарын конвенцийн дагуу Онон голын салаа болон Хурх Хүйтний ай сав нутаг нь хамгаалалттай нутаг. Онон голын ай сав нутагт дахь уул уурхайн үйл ажиллагаа нь Эдийн засаг, Нийгэм болон Соёлын эрхийн тухай олон улсын пактаар хамгаалагдсан бизнесийн байгууллагуудын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхийг хүндэтгэх үүргийг тодорхой зааж өгсөн НҮБ-ын Бизнес болон Хүний эрхийн чиглүүлэх зарчмуудыг (12- р зарчим) зөрчих эрсдэл үүсгэж байна.

Failure to do so would also contradict with the Framework Principles on Human Rights and Environment established by the UN Special Rapporteur on Human Rights and the Environment.¹ Mongolia is also responsible for conserving its biological diversity, using its resources in a sustainable manner as a contracting party of the Convention on Biological Diversity² and of the Ramsar Convention on Wetlands of International Importance, under which the basin of Khurkh-Khuiten, a tributary of the Onon River, is listed as a protected site. Mining operations in the Onon River basin also risk to infringe on the UN Guiding Principles on Business and Human Rights, which clearly define the business enterprises' responsibility to respect internationally recognised human rights (Principle 12), as the ones protected by the ICESCR.


1 НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлийн тогтоол A/HRC/37/59. Аюулгүй, цэвэр, эрүүл, тогтвортой орчинд амьдрахтай холбоотой хүний эрхийн үүргийн асуудлаарх Тусгай Илтгэгчийн Тайлан (2018) [цахимаар] http://ap.ohchr.org/documents/dpage_e.aspx?si=A/HRC/37/59-аас үзнэ үү.

UN Human Rights Council resolution A/HRC/37/59. Report of the Special Rapporteur on the issue of human rights obligations relating to the enjoyment of a safe, clean, healthy and sustainable environment. (2018). [online] Available at: http://ap.ohchr.org/documents/dpage_e.aspx?si=A/HRC/37/59

2 Биологийн Олон янз байдлын тухай конвенци 1992 он. <https://www.cbd.int/doc/legal/cbd-en.pdf>
1992 Convention on Biological Diversity. Available at: <https://www.cbd.int/doc/legal/cbd-en.pdf>


Зөвхөн байгаль орчин гэлтгүй мөн Биндэр болон Батширээт сумдын ард иргэдэд ирж буй дарамт нэмэгдэж байна. Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг “Онон голоо хамгаалъя” хөдөлгөөний хүний эрхийн хамгаалагчид үл мэдэгдэх хүмүүс утсаар дарамталж үйл ажиллагаагаа зогсоохыг шаардсан гэж ярьж байсан. Үүний адилаар Батширээт сумын хоёр иргэнийг “хуурамч тэмцэгч” гэж цоллон сэтгэлзүйн дарамт үзүүлсэн, өөрийн эрх ашгийн төлөө уул уурхайн эсрэг тэмцсэн гэж буруутгасан байна. Ийм төрлийн заналхийлэл сүрдүүлгийг огт шалгадаггүй төдийгүй эдгээр үйлдлүүд нь Иргэний болон Улс төрийн эрхийн олон улсын пактын 19-р зүйлээр Монгол улсын хүлээсэн хөндлөнгийн оролцоогүйгээр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөгөө эдлэх үүрэгтэй зөрчилдөж буй юм. Мөн энэхүү үйлдэл нь НҮБ-ын Хүний эрхийн хамгаалагчдын тухай тунхаг, тухайлбал, 5, 6, 7 болон 12-р зүйлүүдтэй зөрчилдөж байна.

Not only the environment, but also the people of Binder and Batshireet soums are under increased pressure. Community-based HRDs from the “Save Onon River” movement claimed that they have been receiving multiple threats by phone from unknown people, urging them to stop their advocacy work. In a similar fashion, two citizens from Batshireet Soum denounced the psychological burden of being labelled as “fake activist”, accused of protesting against the mining operations for their own personal gains. These acts of intimidations have not been investigated and clashes with Mongolia’s obligations under Article 19 of the International Covenant on Civil and Political Rights (ICCPR), which protects the right to hold opinions without interference. Moreover, it contradicts with the UN Declaration on HRDs, in particular Article 5, 6, 7, and 12.



Монгол улс нь Тогтвортой Хөгжлийн Зорилгууд 2030 хөгжлийн хөтөлбөрийг идэвх санаачлагатай хүлээн авч баталсан бөгөөд уул уурхайн үйл ажиллагаа нь ТХЗ 1 (ядуурлыг устгах), ТХЗ 2 (өлсгөлөнг зогсоох), ТХЗ 6 (Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах), ТХЗ 15 (хуурай газрын экосистемийг хамгаалах), ТХЗ 16 (энх тайван, шударга ёсыг цогцлоох)-ын биелэлтэд саад болж болзошгүй юм. Биндэр сумын ард иргэд болон албан тушаалтнуудаас цуглуулсан мэдүүлгүүд нь Онон гол бохирдоход ойрхон байгааг илэрхийлсэн төдийгүй ард иргэд Онон голд загасчлах, голын усанд орохоос татгалзах болсон байна. Онон голын ай сав нутгийг уул уурхайгүй болгох тодорхой арга хэмжээг нэн даруй авахгүй бол Биндэр сумын ард иргэдийн айдас болгоомжлол тун удахгүй бодитой болох нь дамжиггүй.

Mongolia has also enthusiastically adopted the Sustainable Development Goals (SDGs) and the 2030 Agenda; all these mining operations could specifically compromise the achievements of SDG 1 (no poverty), SDG 2 (zero hunger), SDG 6 (clean water and sanitation), SDG 15 (life on land), and SDG 16 (peace, justice and strong institutions). Testimonies collected from community members and local authorities from Binder Soum indicate that there is very little time left before the Onon River is permanently contaminated, as people already start avoiding fishing or bathing in the river. If concrete measures are not taken to ensure that the Onon River basin area is free from mining operations, the fears of the Binder's local community and authority will quickly turn into reality.



**"Бид ирээдүй хойч үеийнхээ
төлөө арга хэмжээ авах хэрэгтэй
байна. Бид байгалиа хамгаалж
тэдэнд үлдээх ёстой.
Бид уул уурхайгаас хэт хараат
болохгүй байх ёстой."
(Биндэр сумын иргэн)**

**"We need to take action for our
future generations,
we need to preserve our nature
for them. We need to make sure
that mining does
not become an essential part of
our livelihood."
(Binder Soum residents)**

Батноров сумын хувьд нинжа нарын үйл ажиллагаа малчдын болон малын тэжээлийн гол эх үүсвэр болох бэлчээрийн газар байсан нутгийн хөрсийг ихээхэн эвдсэн. Монгол улсын Ашигт малтмалын хуулийн (2006)³ 7.3-р зүйлийг илт зөрчсөн хууль бус уурхайн ажиллагаа нь Монгол улсын иргэний Үндсэн хуулийн 16.2-р зүйлээр хамгаалагдсан эрхийг зөрчиж байгаа төдийгүй мөн Эдийн засаг, Нийгэм болон Соёлын Олон улсын пактын 11-р зүйлээр баталгаажсан амьдрах эрхийг зөрчиж буй юм. Батноров сум болон Хэнтий аймгийн захиргааныхан гар аргаар олборлогчдын үйл ажиллагаа нь авилга авсан хууль хэрэгжүүлэгч албан тушаалтнуудын үгсэн хуйвалдаж үнэт чулуу дамлан борлуулдаг томоохон гэмт хэргийн сүлжээтэй холбоотой байж болзошгүй гэж ярьсан юм. Зохион байгуулалттай гэмт хэрэг эсэхээс үл хамааран гар аргаар олборлогчид нь нэн ядуурлын нөхцөл байдалтай, нийгмээс тусгаарлагдсан, эрэгтэй, эмэгтэй хүмүүс хийгээд хүүхдүүд амьжиргаагаа залгуулахын тулд амиараа дэнчин тавьж аюулгүй байдлын стандартыг баримтлалгүйгээр ухсан нүх рүү орж байна. Үүссэн энэ нөхцөл байдал нь 2030 Хөтөлбөрийн гол зүйл болох Хөгжлөөс хэн ч үлдэх, хоцрох ёсгүй гэсэн уриа, ялангуяа ТХЗ 1, 2 болон 10 (тэгш бус байдлыг бууруулах)-г хэрэгжүүлнэ гэсэн Монгол улсын үүрэг амлалттай зөрчилдөж буй юм.

In Batnorov Soum, ninja mining activities have already heavily damaged the soil of what once was a very rich pasture land, key source of food for both the herders and their cattle. These illegal mining activities, a part from explicitly violating Article 7.3 of the Minerals Law (2006),³ infringe the Mongolians' constitutional right protected by Article 16.2 and their right to livelihoods guaranteed by Article 11 of the ICESCR. According to the local authorities in Batnorov Soum and Khentii Aimag, part of the ninja mining activities seem to be connected to a larger criminal network selling precious gems abroad with the connivance of corrupted law enforcement officials. However, regardless of the criminal machinery behind it, ninja mining also reveals a condition of extreme poverty and social exclusion, pushing men, women, and children into digging holes without any security standards in place, risking their lives to make a living. This condition clashes with Mongolian Government's pledge to leave no-one behind in the spirit of the Agenda 2030, and in particular SDG 1, 2, and 10 (reduced inequalities).

³ Ашигт малтмалын тухай Хууль (2006), 7.3-р зүйл: Тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглоно. Minerals Law (2006), Article 7.3: Conducting exploration or mining without a valid license is prohibited.

Баримтжуулах томилолтын баг орон нутгийн албан тушаалтнууд болон Монгол улсын ХЭҮК-ийн салбарын ажилтан руу халдсан, тэдэн рүү дайрсан, доромжилсон тухай сонсож, санаа зовнисон. ХЭҮК нь хүний эрхийн зөрчлийг шалгах, холбогдох албан тушаалтнуудад мэдэгдэх гол үүрэг гүйцэтгэх ёстой ч санхүү болон хүн хүч дутмаг, ялангуяа сум орон нутгийн хэмжээнд байхгүй гэж үзсэн. Сэтгэл зовоосон энэхүү нөхцөл байдал нь Хүний эрхийн байгууллагуудын Дэлхийн эвслийн Магадлан итгэмжлэлийн дэд хорооноос ХЭҮК-д өгсөн Парисын Зарчмуудын бүрэн хэрэгжилт болон Парисын Зарчмуудыг бүрэн хэрэгжүүлэх гэсэн шалгуур үзүүлэлтийг багтаасан ТХЗ 16-тай зөрчилдөж байна.

The FFM team was also concerned to hear about the physical attacks and intimidations against local authorities and a representative of the NHRCM. The latter should play a key role in ensuring that human rights violations are investigated and brought to the attention of the relevant authorities, but seem to lack financial and human resources, especially at the provincial level. This particularly worrying situation clashes with the 'A' status of full compliance with the Paris Principles granted by the Global Alliance of National Human Rights Institutions (GANHRI) Sub-Committee on Accreditation (SCA) to the NHRCM, and with the SDG 16, which includes the compliance to the Paris Principles as one of its indicators (16.A.1).



Horses grazing in Dornod Aimag, Khentii Province

Цагаан-Овоо сумын захиргаа, ялангуяа 2-р багийн засаг дарга 13 өрх айл болон Степ Гоулдын уурхайн талбай давхардахгүй байх нөхцлийг хангах ёстой. Газрын зохицуулалтын талаар мэдээлэл өгөх, Степ Гоулд компанид газар олгохдоо газар давхардуулан олгоогүй эсэхийг шалгах ёстой байсан. Степ Гоулд компанид газар олгохын өмнө Монгол улсын Үндсэн хууль болон ЭЗНСЭОУП (11-р зүйл) зэрэг олон улсын стандартаар олгогдсон эрхийг хангахын тулд газартай холбоотой зохицуулалтуудын талаарх мэдээллийг өгөх замаар үүнийг хэрэгжүүлэх шаардлагатай байсан. Степ Гоулдын үйл ажиллагаа дөнгөж эхлээд байгаа хэдий ч Баримтжуулах томилолтын баг худгийн ус бохирдож мал хордох вий гэсэн орон нутгийн ард иргэд хийгээд малчдын нэмэгдэж буй болгоомжлол айдсыг бичиж баримтжуулсан. Уурхайн талбарын ойр орчимд амьдардаг айл өрхүүдийн аж амьдралд тоос, дуу чимээ нэгэнтээ сөргөөр нөлөөлж эхэлсэн байна. Үүссэн сөрөг нөлөөлөл нь НҮБ-ийн чиглүүлэх зарчмын 12-р зарчим болон ТХ36 (Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах)-тай зөрчилдөж буй юм.



Shoe left by a ninja miner in Batnorov Soum, Khentii Aimag

In Tsagaan-Ovoo Soum, the local Government, and in particular the Governor of the Brigade (Bag) number 2, should have ensured that there is no overlap between the land of 13 households and the mining site of Steppe Gold. This should have been done by raising awareness about land-related regulations, double-checking the land register before granting land to Steppe Gold, in order to ensure the respect of the rights guaranteed by Mongolian Constitution, especially Article 16.2, and international standards such as the ICESCR (Article 11). Although Steppe Gold operations are at an early stage, the FFM team recorded the growing fear of local communities and herders that water wells will be contaminated and cattle poisoned, while dust and noise is allegedly already negatively affecting the standard of living of the families living nearby the mining site. These adverse impacts would already clash with Principle 12 of the UNGPs as well as SDG 6 (clean water and sanitation).

Цаашилбал, баримтжуулах томилолтын багийнхан уул уурхайн үйл ажиллагаатай тэмцэж буй Хүний эрхийн хамгаалагчдад Степ Гоулдын гэрээлсэн гэх хамгаалалтын албаныхан сэтгэлзүйн дарамт үзүүлж, биед нь халдсаныг тэмдэглэсэн. Энэ нь НҮБ-ын чиглүүлэх зарчмуудын 12-р зарчмыг, ялангуяа Иргэний болон улс төрийн олон улсын пакт, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх (19-р зүйл) болон тайван хуран цуглах эрх (21-р зүйл)-ийн хамгаалалтын хувьд ноцтой зөрчил юм. Орон нутгийн засаг захиргаа НҮБ-ын ХЭХчдын тухай тунхагийн 9 (5)-р зүйлд болон ТХЗ 16 –д заасны дагуу шударга ёсны хүртээмж хийгээд хүний эрхийг хөхүүлэн дэмжигчийн үүргийн ач холбогдлыг баталгаажуулж, шуурхай, шударга хянан шалгалт явуулах шаардлагатай.

Furthermore, the FFM team recorded how HRDs opposing the mining operation have been psychologically and physically abused by security personnel allegedly hired by Steppe Gold. This is a flagrant violation of the said Principle 12 of the UNGPs, especially in relation to the ICCPR and the protection of the rights to freedom of expression (Article 19) and peaceful assembly (Article 21). Local authorities are yet to conduct prompt and impartial investigations, in line with Article 9 (5) of the UN Declaration on HRDs, and SDG 16, which recognises the importance of access to justice and the role of human rights advocates.

"нөхцөл байдал их аймшигтай байсан; тэд нар миний хувцсыг урсан. Би үхтлээ айсан, амиа алдах нь гэж бодсон."

(хамгаалалтын албаныхны дайралтанд өртсөн Цагаан-Овоо сумын эмэгтэй хүний эрхийн хамгаалагчийн яриа.)

"The situation was very scary; my clothes were torn apart by them. I was scared for my life, I thought I would die at that time."

(An HRD from Tsagaan-Ovoo Soum recalling the harassment perpetrated by the security personnel)

Баримтжуулах томилолтын багийнхан дээр дурьдсан бүх сумдад зөрчлүүдийг нэн даруй шалгах үүргээ хэрэгжүүлэх үүрэгтэй орон нутгийн болон төв засаг захиргааны эс үйлдэл болон Монгол улсын хууль журам болон олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байгаад цөхөрч байгааг тэмдэглэсэн юм. Ярилцлага өгсөн орон нутгийн иргэд болон малчдын олонх нь үе дамжин амьдарсан газар орныг нь бохирдуулах, хайртай хүмүүс нь бохирдсон сүйтгэгдсэн орчинд амьдрах ёсгүй гэсэн хатуу байр суурьтай байгаагаа илэрхийлсэн. Уул уурхай санхүүгийн хувьд ихээхэн ач холбогдолтой гэдгийг орон нутгийн иргэд маш сайн ойлгохын сацуу аюул заналхийлэл, доромжлолтой нүүр тулж байгаа хэдий ч тэд хариуцлагатай уул уурхай гэсэн онолд үл автан тэдний газар нутгаа хайрлах сэтгэл нь бүхнээс давамгайл байгаа юм.

In all the above mentioned soums, the FFM team observed a growing sense of frustration over the inaction of local and central governments to promptly investigate possible violations, and ensure the respect of Mongolia's national laws and international obligations. The very large majority of local communities and herders interviewed were firmly determined to not let the land where they have lived for generations be contaminated and their beloved ones grow up in a polluted environment. Although perfectly aware of the possible financial gains that mining would bring to them, and despite threats and intimidations, they did not buy in the concept of responsible mining but have chosen to put the love for their land first.

Зөвлөмж **Recommendations**

Монгол улсын Засгийн газарт өгөх зөвлөмж **Recommendations to the Government of Mongolia**

Хүний эрхийн хамгаалагчдын тухайд: **On the protection of human rights defenders:**

(А) Эмэгтэй/ХЭХ-чдад шийтгэлээс айхгүйгээр эрх хамгаалах үйл ажиллагаагаа явуулах нөхцлийг бий болгохын тулд Хүний Эрхийн Хамгаалагчийн тухай хуулийн одоогийн төслийг Эмэгтэй ХЭХ болон нэн ялангуяа хөдөө орон нутагт байгаа ХЭХ-чидтай зөвлөлдөж сайжруулан, үр дүнтэй хэрэгжүүлэлт бүхий хуулийг батлах.

(A) To strengthen the current draft of the Human Rights Defenders Protection Law in consultation with women human rights defenders (WHRDs) and human rights defenders (HRDs), especially those based in rural areas, in order to create an enabling environment for W/HRDs to conduct their human rights work without fear of reprisals, and enact the law with full resources for effective implementation.

(Б) Хүний эрхийг хамгаалахаар ажиллаж буй бүх хүмүүсийн эрх чөлөөг бүрэн хүндэтгэх замаар олон улсын хүний эрхийн пакт болон стандартууд, нэн ялангуяа Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын пактын дагуу болон НҮБ-ын Хүний эрхийн хамгаалагчдын тухай тунхагаар хүлээсэн үүргийг харгалзах.

(B) To observe their obligations under international human rights treaties and standards, particularly the International Covenant on Civil and Political Rights (ICCPR), by fully respecting the freedoms of all people working to defend human rights, and the UN Declaration on Human Rights Defenders.

(B) Бизнестэй холбоотой асуудлууд дээр ажиллаж байгаа эмэгтэй/ХЭХ-дын хууль ёсны үйл ажиллагааг санаачлагатайгаар дэмжих, үүнд НҮБ-ын Хүний эрхийн хамгаалагчдын тухай тунхагийн 9 (5)-р зүйлд заасны дагуу Онон голын ай сав нутаг болон Цагаан-Овоо сумын нутаг дэвсгэрт эмэгтэй/ХЭХ-чдын эрхийг зөрчсөн зөрчлүүдийг нэн даруй, хараат бусаар, шударгаар хянан шийдвэрлэх.

(C) To proactively protect the legitimate activities of W/HRDs working on business-related issues, including conducting prompt, independent, and impartial investigations on the cases of violations against W/HRDs in the areas of the Onon River basin and Tsaagan-Ovoo Soum, as per Article 9 (5) of the UN Declaration on Human Rights Defenders.

(Г) Бизнестэй холбоотойгоор хүний эрхийн зөрчил гарсан нөхцөлд НҮБ-ын чиглүүлэх зарчимд заасны дагуу Эмэгтэй/ХЭХ, орон нутгийн ард иргэд болон малчид үр дүнтэй шийдвэрлэх арга механизмыг хэрэгжүүлэн Монгол улсад бүртгэлтэй корпорациуд болон төрийн бус бусад оролцогч талуудад байгаль орчин болон хүний эрхийн аливаа зөрчлийн бүрэн хариуцлагыг хүлээлгэнэ.

(D) To ensure, as instructed by the UNGPs, that W/HRDs, local communities and herders are able to access effective remedies when business-related human rights abuses occur, holding corporations and other non-state actors operating in Mongolia fully accountable for any environmental and human rights violations.

(Д) ХЭҮК-ийн ХЭХ болон байгаль орчныг хамгаалахтай холбоотой үйл ажиллагаанд Парисын Зарчмын (2) дагуу санхүүгийн болон хүн хүчний шаардлагатай нөөцийг хуваарилах.

(E) To strengthen the work of NHRCM in relation to the protection of W/HRDs and environment, by allocating appropriate financial and human resources, in compliance with the Paris Principles (2).

(E) Аймгуудад үйл ажиллагаа явуулж буй ХЭҮК-ийн албан хаагчдын эрх мэдлийг тусгайлан нэмэгдүүлж тухайн нутаг оронд гарсан эмэгтэй/ХЭХ-ийн зөрчлүүдийг нэн даруй хянан шийдвэрлэх нөхцлийг бий болгох төдийгүй ХЭҮК-ийн дотоод хүнд суртлыг арилгах.

(F) To specifically expand the mandate of NHRCM representatives based in the provinces to enable them to respond to urgent W/HRDs cases in their area, by also simplifying bureaucratic processes within the NHRCM.

(Ж) Эдийн засаг, Нийгэм болон Соёлын эрхийн тухай олон улсын пактын 11-р зүйлээр хүлээсэн үүргийн дагуу эмэгтэй/ХЭХ-чдыг оролцуулан Монгол улсын бүх иргэдийн амьжиргааны зохих түвшинг хангах, баталгаажуулах.

(G) To guarantee an adequate standard of living of all Mongolian people, including W/HRDs, in line with the country's obligations under Article 11 of the International Covenant on Economic, Social, and Cultural Rights (ICESCR).

Хүний эрх болон байгаль орчин хамгаалах тухайд: **On the protection of human rights and environment:**

(A) Газар нутгийн анхны оршин суугчдын эрхийг хуулиар хамгаалж буй эсэхийг баталгаажуулах, газар эзэмшигч газрын гэрчилгээ авснаас хойш хоёр жилийн хугацаанд газраа хашаалах ёстой гэсэн Газрын тухай хуулийн 40.1.6-р заалтыг эргэн харах.

(A) To ensure that the rights of local herder communities are protected by law, revise article 40.1.6 of the Land Law, requiring owners to utilise their land for a specific purpose within two years-time since they receive a land certificate.

(Б) Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулинд оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг эргэн харах, хамгаалалтын бүсийг голын эргээс хамгийн багадаа 200-1,000 метрээр тогтоож нэмэгдүүлэх.

(B) To review the amendments made to the Law to Prohibit Mineral Exploration and Mining Operations at Headwaters of Rivers, Protected Zones of Water Reservoirs, and increase the safety zones back to at least 200 to 1,000 meters from riverbanks.

(B) Бизнесийн байгууллагууд, ялангуяа уул уурхайн салбарын компаниуд улсын хууль журам, бодлого, ялангуяа Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх үнэлгээний тухай хууль болон Эдийн засаг, нийгэм болон соёлын эрх, Иргэн болон улстөрийн эрхийн олон улсын пакт, Биологийн олон янз байдлын тухай конвенц (Биологийн олон янз байдлын пакт), Ус, намгархаг газрын тухай Рамсарын конвенц, НҮБ-ийн Бизнес ба Хүний эрхийн чиглүүлэх зарчим зэрэг стандартуудын дагуу үйл ажиллагаа явуулж буй эсэхийг баталгаажуулах.

(C) To ensure that business enterprises, in particular in the mining sector, operate in full compliance with national legislation and policies, in particular the Law to Prohibit Mineral Exploration and Mining Operations at Headwaters of Rivers, Protected Zones of Water Reservoirs, Minerals Law, Law on Water, and Environmental Impact Assessment Law, as well as international standards such as the ICESCR, ICCPR, Convention on Biological Diversity (Biodiversity Treaty), Ramsar Convention on Wetlands, and the UNGPs.

(Г) Холбогдох бүх оролцогч талууд, ялангуяа иргэний нийгэм, орон нутаг болон хувийн компаниудтай зөвлөлдөж НҮБ-ын чиглүүлэх зарчимд заасны дагуу Бизнес ба Хүний эрхийн үндэсний хэмжээний ажлын төлөвлөгөө боловсруулах тодорхой алхмуудыг хэрэгжүүлэх.

(D) To take concrete steps for the development of a National Action Plan on Business and Human Rights in close consultation with all relevant stakeholders, in particular civil society actors, local communities and business sector, in line with the UNGPs.

(Д) НҮБ-ын байгаль орчны зөв удирдлага, аюултай бодис болон хог хаягдлын устгалын хүний эрхэд үзүүлж буй нөлөөлөл хариуцсан Тусгай илтгэгчийг албан ёсоор урьж Монгол улсад албан ёсны айлчлал хийлгэх, ийм төрлийн механизмтай бүрэн хэмжээнд хамтран ажиллах.

(E) To officially invite the UN Special Rapporteur on the implications for human rights of the environmentally sound management and disposal of hazardous substances and wastes to conduct an official visit to Mongolia and fully cooperate with such mechanisms.

Хэнтий аймгийн Захиргаанд өгөх зөвлөмж: **Recommendations to Khentii Aimag Government:**

(A) Онон голын дөрвөн салааг Үндэсний хэмжээний гол мөрний нэгдсэн сангаас хассан гэж “Онон голоо хамгаалъя” хөдөлгөөн болон Биндэр болон Батширээт сумдын бусад иргэдийн хийсэн гомдлыг Засгийн газартай хамтран нэн даруй хянан шийдвэрлэх.

(A) To promptly investigate, in coordination with the central Government, on allegations made by the “Save Onon River” movement and other residents from the soums of Binder and Batshireet on the deletion of four tributaries of the Onon River from the National River Database.

(Б) Засгийн газар болон сумуудтай хамтран хууль бус уурхайн (нинжа) асуудлыг шийдвэрлэх нэгдсэн стратегийг боловсруулах, газар нутгийг нөхөн сэргээх, эдгээр уурхайнуудын ойр орчимд амьдарч буй ард иргэдийг бодитоор хамгаалах, нинжа нарт нийгмийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

(B) To develop, together with the central Government and soums authorities, a holistic strategy to tackle the issue of illegal artisanal mining (ninja mining), looking into land rehabilitation, physical protection of communities living near these sites, and social and financial support to the ninja miners themselves.

Батширээт болон Биндэр сумын Захиргаанд өгөх зөвлөмж:

Recommendations to Batshireet and Binder Soums Government:

(A) Сумдын ард иргэдийн хооронд тайван яриа хэлэлцээр өрнүүлэхийг дэмжих, мөргөлдөөн болж газар авах, үг хэллэг болон бие махбодийн хүчирхийллийн аливаа үйлдэл хийхгүй байхыг баталгаажуулах.

(A) To promote dialogue and peaceful confrontation between the two communities, ensuring that no acts of verbal or physical violence take place and escalate into a conflict.

(Б) Газар болон Байгаль орчны байцаагчдаар нараар дамжуулан Онон голын ай сав нутагт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудыг тогтмол хянах, ус, хөрсний дээж тогтмол авч шинжлэн үр дүнг олон нийтэд мэдээлэх.

(B) To regularly monitor through land and environmental inspectors the operations of all mining companies operating in the Onon River basin area, by also regularly testing samples of water and soil, and make the results public.

Цагаан-Овоо сумын захиргаанд өгөх зөвлөмж: Recommendations to Tsagaan-Ovoo Soum Government:

(A) Нутаг орон дахь уул уурхайн үйл ажиллагааг эсэргүүцэж буй орон нутгийн иргэд, малчид, Эмэгтэй ХЭХ/ХЭХ-ийн эсрэг аливаа төрлийн заналхийлэл, хүчирхийллийг нэн даруй хянан шалгах, буруутай этгээдүүдэд хариуцлага тооцох, үр дүнтэй, тохиромжтой эрхээ хамгаалах арга механизмуудын хүртээмжийг нэн даруй хэрэгжүүлэх.

(A) To promptly investigate all forms of threats and violence against local community members, herders, W/HRDs opposing mining operations in the area, holding perpetrators accountable and ensure prompt access to effective remedies, which should be accessible, affordable, adequate, and timely.

(Б) Газрын болон байгаль орчны байцаагч нараар дамжуулан Степ Гоулд компанийн үйл ажиллагааг тогтмол хянах, аливаа төрлийн бохирдол, ялангуяа худаг болон тоосжилттой холбоотой эрсдэлээс сэргийлэн эдийн засаг, нийгэм болон соёлын эрхийн тухай олон улсын пактын 11-р зүйлд заасны дагуу хүний амьдрах эрхийг хамгаалах.

(B) To regularly monitor through land and environmental inspectors the operations of Steppe Gold, preventing any form of pollution, particularly in relation to water wells and dust, as well as protecting the people's right to livelihoods as per Article 11 of the ICESCR.

(B) Орон нутгийн иргэд болон малчдад газар ашиглалт, уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой холбогдох бүх хууль журмыг мэдүүлэх, ойлгуулах, газрын гэрчилгээ болон бүртгэлтэй холбоотой бүхий л явцад тэднийг дэмжих замаар үе удмаараа амьдарч ирсэн газар нутгийг уул уурхайн компаниудад эзлүүлэхгүй байх.

(C) To ensure that all relevant legislation on the usage of land and mining operation are widely understood by the local community and herders, actively supporting them with the processes related to land certificate and register, so that no land occupied for generations can be taken by mining companies.

(Г) Степ Гоулд компаниас санхжүүжүүлж буй сургалтын тэтгэлэгт хөтөлбөрүүд болон бусад бүх санаачлагууд нь орон нутгийн бүх иргэдэд эрх тэгш, ил тод, нээлттэй хүртээмжтэй байх нөхцлийг хангах.

(D) To ensure that all community members are allowed to access scholarship programmes and other initiatives funded by Steppe Gold in an equal, open, and transparent way.

Уул уурхайн Айвуунтэс болон Пегматит компаниудад өгөх зөвлөмж:

Recommendations to Aivuuntes and Pegmatite mining companies:

(A) НҮБ-ын чиглүүлэх зарчмуудын 12-р зарчимд заасны дагуу Онон голын дагуух байгаль орчин болон ард иргэд, малчдын амьдрах эрхэд хор хохирол учруулж болзошгүй бүх төрлийн үйл ажиллагааг зогсоох.⁴

(A) To halt any kind of operations that can potentially damage the environment and the right to livelihoods of the communities and herders living both upstream and downstream the Onon River, in line with Principle 12 of the UNGPs.⁴

⁴ Бизнесийн нэгжүүдийн хүний эрхийг хүндэтгэх үүрэг гэдэг нь хамгийн багадаа олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхийг хэлж буй бөгөөд Хүний эрхийн тухай Олон улсын хууль болон Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын Суурь зарчим болон Ажлын байран дахь эрхийн тухай тунхагаар баталгаажсан суурь эрхийн тухай зарчмуудад тусгасан зүйл болно.

The responsibility of business enterprises to respect human rights refers to internationally recognised human rights understood, at a minimum, as those expressed in the International Bill of Human Rights and the principles concerning fundamental rights set out in the International Labour Organization's Declaration on Fundamental Principles and Rights at Work.

(B) НҮБ-ын чиглүүлэх зарчмуудын 17-р зарчимд заасны дагуу ус болон хөрсний дээжийг тогтмол авч магадлан итгэмжлэгдсэн лабораториудаар шинжлүүлэх, шинжилгээний үр дүнг олон нийтэд мэдээлэх, уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөлөлд өртсөн бүх айл өрхүүдэд зохих нөхөн төлбөрийг олгох.

(B) To conduct regular tests of water and soil samples through certified laboratories, make the results public, and effectively compensate all families that have been eventually affected by mining operations, in line with the Principle 17 of the UNGPs.

(B) Уул уурхайн үйл ажиллагааны бүхий л үе шатуудад холбогдох хууль журам, бодлогууд, ялангуяа гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль, Ашигт малтмалын хууль болон Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний хууль болон НҮБ-ын чиглүүлэх зарчмууд зэрэг олон улсын хэм хэмжээ, стандартуудыг чандлан мөрдүүлэх.

(C) To ensure that all phases of their operations are in full compliance with the relevant national legislations and policies, in particular the Law to Prohibit Mineral Exploration and Mining Operations at Headwaters of Rivers, Protected Zones of Water Reservoirs, Minerals Law, Law on Water, and Environmental Impact Assessment Law, and international standards such as the UNGPs.

Степ Гоулд компанид өгөх зөвлөмж: Recommendations to Steppe Gold:

(A) Уул уурхайн үйл ажиллагааг эсэргүүцэж буй эмэгтэй/ХЭХ-чдын эсрэг гэрээгээр ажиллаж буй хамгаалалтын албаныхны үйлдсэн сүрдүүлэг, хүчирхийллийн тохиолдлуудыг хянан шалгах дотоод шалгалт хийх, цаашид ийм хэрэг үйлдэгдэхгүй байх нөхцлийг хангах, бие махбодийн болон сэтгэл санааны хор хохирол амссан хохирогчдод зохих ёсны нөхөн төлбөр олгох.

(A) To conduct internal investigations looking into any kind of harassment and violence perpetrated by subcontracted security personnel against W/HRDs protesting against the mining operation, ensure no such incidents happen anymore, and justly compensate victims for any kind of physical or psychological damages.

(Б) Орон нутгийн засаг захиргаатай хамтран мал амьтны сэжигтэйгээр үхсэн хорогдсон, өвчилсөн нөхцөл байдлыг нэн даруй хянан шалгах, ус болон хөрсний дээжийг үргэлжлүүлэн тогтмол шинжлэх, шинжилгээний үр дүнг олон нийтэд мэдээлэх.

(B) To promptly investigate together with local authorities any cases of cattle's suspicious deaths and illnesses, while continuing to test water and soil samples and make the results public.

(B) НҮБ-ын чиглүүлэх зарчмуудын 12-р зарчимд заасны дагуу малчдын олон үеэрээ амьдарч ирсэн газарт уурхайн суурин байгуулснаар малчдын амьдралд уурхайн тоосжилт, худгийн ус бохирдох зэрэг сөрөг нөлөө үүсгэхгүй байх тодорхой арга хэмжээг цаг тухайд авах.

(C) To take timely and concrete measures to ensure that the right to livelihoods of the herders that have been setting up their camps nearby the mining site for generations is not negatively affected by dust and pollution of water wells, in line with Principle 12 of the UNGPs.

(Г) НҮБ-ын баримтлах зарчмын 17-р зарчмын дагуу хүний эрхийг зөрчих сөрөг нөлөөллүүдийг хэрхэн тодорхойлж, урьдчилан сэргийлж, бууруулж байгаа талаар нарийвчилсан судалгаа хийх.

(D) To carry out human rights due diligence in order to identify, prevent, mitigate, and account for how they address adverse human rights impacts in line with Principle 17 of the UNGPs.

(Д) Үйл ажиллагааны бүх үе шатууд нь дотоодын холбогдох хууль журам, бодлогууд, ялангуяа Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль, Ашигт малтмалын хууль болон Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний хууль болон НҮБ-ын чиглүүлэх зарчмууд зэрэг олон улсын хэм хэмжээ, стандартуудыг чандлан мөрдөх.

(E) To ensure that all phases of their operations are in full compliance with the relevant national legislations and policies, in particular the Law to Prohibit Mineral Exploration and Mining Operations at Headwaters of Rivers, Protected Zones of Water Reservoirs, Minerals Law, Law on Water, and Environmental Impact Assessment Law, and international standards such as the UNGPs.

НҮБ-ын Хүний Эрхийн Хамгаалагчдын нөхцөл байдлын Тусгай Илтгэгчид өгөх зөвлөмж:

Recommendations to the United Nations Special Rapporteur on the Situation of Human Rights Defenders:

(A) Эмэгтэй/ХЭХ-чдын саналыг авч Хүний Эрхийн Хамгаалагчдын Хуулийг батлуулах талаар Монгол улсын Засгийн Газарт зөвлөмж хүргүүлэх.

(A) To encourage the Government of Mongolia to enact the Human Rights Defenders Protection Law by genuinely considering inputs from W/HRDs.

(Б) Монгол улсын Засгийн Газарт олон нийтийн оролцоо, орон нутгийн ард иргэд болон эмэгтэй ХЭХ/ХЭХ-чдэд нөлөөлөх аливаа шийдвэрийн талаар тэдэнтэй зөвлөлдөхийн үр нөлөө, ач холбогдлыг онцгойлон сануулах

(B) To stress to the Government of Mongolia the importance of public participation and meaningful consultation with communities and W/HRDs in any decisions affecting them.

(B) Эмэгтэй ХЭХ/ХЭХ-чдыг сүрдүүлэх, заналхийлэх, хүчирхийлсэн нөхцөлд компаниудтай албан ёсны шаардлага хүргүүлэх.

(C) To send formal communications to companies with regards to threats, intimidation, and harassment against W/HRDs.

(Г) НҮБ-ын Тусгай Процедурын Эрх бүхий бусад ажилтнууд болон НҮБ-ын бусад харьяа агентлагуудтай хамтын ажиллагааг бэхжүүлж хүний эрхийн хамгаалагчдын эрхийг зөрчих асуудлыг шийдвэрлэх.

(D) To strengthen collaboration with other United Nations Special Procedures Mandate Holders and other UN agencies to address human rights violations against HRDs.

(Д) Монгол улсын Засгийн Газрыг НҮБ-ын ХЭХ-чдын тунхаг, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн Эмэгтэй Хүний Эрхийн Хамгаалагчдын талаарх 6-р тогтоол болон НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлийн эрхээ эдлэх, байгаль орчныг хамгаалах, тогтвортой хөгжлийг хангахад хүний эрхийг хамгаалагчдын гүйцэтгэдэг зангилаа үүргийг цохон тэмдэглэсэн тогтоолыг бүрэн хэрэгжүүлэхийг уриалах.

(E) To urge the Government of Mongolia to fully implement the UN Declaration on HRDs, the UN General Assembly Resolution on WHRDs,⁵ and the UN Human Rights Council Resolution on Recognizing the contribution of environmental human rights defenders to the enjoyment of human rights, environmental protection and sustainable development.⁶

⁵ УНҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоол A/RES/68/181. дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн Хүний эрх болон Суурь эрх чөлөөг сурталчлах, хамгаалах хүмүүс, бүлэг болон нийгмийн бүтцүүдийн үүрэг. [цахимаар] https://www.un.org/en/ga/search/view_doc.asp?symbol=A/RES/68/181

UN General Assembly resolution A/RES/68/181. Promotion of the Declaration on the Right and Responsibility of Individuals, Groups and Organs of Society to Promote and Protect Universally Recognized Human Rights and Fundamental Freedoms: protecting women human rights defenders. [online] available at: https://www.un.org/en/ga/search/view_doc.asp?symbol=A/RES/68/181

⁶ НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн тогтоол A/HRC/40/L.22/Rev.1. Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хүний эрхийн хамгаалагчдын хүний эрхээ эдлэх, байгаль орчин болон тогтвортой хөгжлийг хамгаалахад оруулж буй хувь нэмрийг хүлээн зөвшөөрөх тухай. [цахимаар] Available at: <https://undocs.org/A/HRC/40/L.22/Rev.1>

UN Human Rights Council Resolution A/HRC/40/L.22/Rev.1. Recognizing the contribution of environmental human rights defenders to the enjoyment of human rights, environmental protection and sustainable development. [online] Available at: <https://undocs.org/A/HRC/40/L.22/Rev.1>

Хүний эрх хөгжил төв (ХЭХТ)

Хүний эрх хөгжил төв нь 1998 онд байгуулагдсан хүний эрх, нийгмийн шударга ёс, хөгжлийн төлөө ажилладаг төрийн бус байгууллага юм. Манай төв нь байгуулагдсан цагаасаа эхлэн эдийн засаг, нийгэм соёлын эрхийг дэмжин хамгаалах, оролцооны аргаар ядуурлыг бууруулах чиглэлээр дэмжлэг туслалцаа шаардлагатай нийгмийн бүлгүүдэд анхаарч ажилласаар ирсэн.

Бид хүний эрхийн үндэсний механизмыг бэхжүүлэх, хөгжлийн албан ёсны зээл тусламжийн үр ашгийг нэмэгдүүлэх, хөгжил дэх иргэний нийгмийн үүрэг ролийг нэмэгдүүлэх, олон улсын хүний эрхийн механизмыг үр дүнтэй ашиглах зэрэг чиглэлүүдээр тодорхой үйл ажиллагаануудыг явуулдаг.

Мөн дээрх чиглэлүүдээр хүний эрх, хууль эрх зүйн нөлөөлөл, өмгөөлөл, мониторинг хийх, судалгаа явуулах, зөвлөмж боловсруулах, мэдээлэл түгээх, сургалт, уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах, ном, гарын авлага хэвлэн түгээх, дотоод гадаадын байгууллагуудтай сүлжээ холбоонд нэгдэх, олон нийтийн кампанит ажил зохион байгуулах, орон нутгийн иргэдийг идэвхижүүлэх, чадавхижуулах ажлуудыг хийж байна.

About CHRD

The Centre for Human Rights and Development (CHRD) is a non-governmental organisation operating as not-for-profit, public-benefit organisation for the purpose of promoting and protecting human rights and social justice in Mongolia. CHRD aims at a developed Mongolia where every individual enjoys the right to participation and development. The organisation's motto is development through human rights. It believes in the fulfillment of human rights as the prerequisite condition for poverty reduction, protection of ecological balance and sustainable development. People's participation in formulation, implementation, monitoring and evaluation of national and local development policies, programs and projects is the sole purpose of ensuring that everyone equally benefits from the results of development.

Хүний эрх болон хөгжлийн Азийн Форум (ФОРУМ-АЗИ)

Хүний эрх болон хөгжлийн Азийн Форум (ФОРУМ-АЗИ) нь Азийн 21 улс орны 81 гишүүн бүхий хүний эрх болон хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Ази дахь хамгийн том гишүүнчлэлтэй байгууллага юм. ФОРУМ-АЗИ нь хүний эрхийн байгууллагууд болон хүний эрхийн хамгаалагчдын хамтын ажиллагаа, түншлэлээр дамжуулан Ази болон дэлхийн бусад улс орнуудад бүх нийтийн хүний эрхийг сурталчлах, хамгаалах үйл ажиллагаа явуулдаг.

ФОРУМ-АЗИ нь дэлхийн өмнөд хэсгийн байгууллага болон сүлжээнүүдтэй түншлэн олон улсын эв санааг бэхжүүлэх зорилготой. Форум-Ази нь 1991 онд байгуулагдсан. 1992 онд Тайландын Бангкок хотод нарийн бичгийн газраа байгуулсан бөгөөд Швейцарийн Женев, Индонезийн Жакарта болон Непалын Катманду хотуудад салбаруудаа нээсэн. Форум-Ази нь НҮБ-ын Эдийн засаг, Нийгмийн Зөвлөлтэй зөвлөлдөх эрх бүхий байгууллага бөгөөд мөн АСЕАН-ын Засгийн газар хоорондын Хүний эрхийн хороотой зөвлөлдөх харилцаатай ажилладаг.

About FORUM-ASIA

The Asian Forum for Human Rights and Development (FORUM-ASIA) is the largest membership-based human rights and development organisation in Asia with a network of 81 members in 21 countries across Asia. FORUM-ASIA works to promote and protect human rights for all, including the right to development, through collaboration and cooperation among human rights organisations and defenders in Asia and beyond. FORUM-ASIA seeks to strengthen international solidarity in partnership with organisations and networks in the global South.

FORUM-ASIA was founded in 1991, and established its Secretariat in Bangkok in 1992. Since then, other offices have been opened in Geneva, Jakarta, and Kathmandu. FORUM-ASIA has consultative status with the UN Economic and Social Council (ECOSOC) and a consultative relationship with the ASEAN Intergovernmental Commission on Human Rights (AICHR).

This publication has been made possible with the generous support of the European Instrument for Democracy & Human Rights (EIDHR), ProtectDefenders.eu, and Swedish International Development Cooperation Agency (Sida).

The contents of this publication are the sole responsibility of FORUM-ASIA and can in no way be taken to reflect the views of the EU, ProtectDefenders.eu, and Sida.





Хүний Эрх Хөгжил Төв
CHRD

